

**БАТАЛСАН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ

ДАРГА.....*Дам*...../Л.ДАГИЙСҮРЭН /

Огноо: *2023.04.23.*

**БОЛОВСРУУЛСАН:**

ДОТООД АУДИТОР.....*А.Сандагдорж*...../А.САНДАГДОРЖ/

Огноо: *2023.04.23.*

БАТЛАВ. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ажлын баримт: АБ1000

Б.АЗЖАРГАЛ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 22-06-23/07

## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН УДИРДАМЖ

### 1. Нийтлэг үндэслэл

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу, Дархан хотын Соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-т Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.10, 4.11-д заасны дагуу дотоод аудит хийж дүгнэлт гаргах, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

### 2. Дотоод аудитын зорилго

Дархан хотын Соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

### 3. Дотоод аудитын хамрах хүрээ

- Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

- 2022 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаа.

### 4. Дотоод аудитын хамрах хүрээний хязгаарлалт

- Аймгийн Төрийн аудитын газрын 2022 оны санхүүгийн аудитын тайланд дурдагдсан асуудлыг дотоод аудитад хамруулахгүй болно.

- Сангийн яамны нэгдсэн удирдамж болон Засаг даргаас тусгайлсан хяналт шалгалтын тайланд дурдагдсан асуудлыг дотоод аудитад хамруулахгүй болно.

### 5. Дотоод аудитын ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Улсын ахлах байцаагч - Л.Дагийсүрэн /99016210/

Дотоод аудитор – А.Сандагдорж /99660033/



## 6. Хэрэгжүүлэх хугацаа

Дотоод аудитыг 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн ажлын 14 хоногт гүйцэтгэнэ.

## 7. Дотоод аудитыг хэрэгжүүлэх гол үе шат

Дараах ажлын горимуудыг ашиглан явуулна.

- Байгууллагын үйл ажиллагаа, эрсдэл ба дотоод хяналтын тогтолцооны талаар мэдээлэл олж авахын тулд асуулга авах, холбогдох баримт бичигтэй танилцах

- Байгууллагын үйл ажиллагааны урсгалыг зураглах, эрсдэл ба хяналтыг тодорхойлж үнэлэх

- Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт

- 2022 оны санхүүгийн баримтууд, Орлого төвлөрүүлэлт

- Хууль тогтоомжийн хэрэгжилт

## 8. Үүрэг хариуцлага

### Дотоод аудитад хамрагдаж буй байгууллага

- Шаардлагатай мэдээлэл, материал, санхүүгийн баримт материалыг аудитын ажлын багт шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх

- Дотоод аудиторт хандаж, дотоод аудитыг хэрэгжүүлэхэд холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах

- Дотоод аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал, тайлбар өгөх

- Аудитын хорооноос гаргасан шийдвэр зөвлөмжийг хэрэгжүүлэх

### Дотоод аудитын ажлын хэсэг

- Дотоод аудитыг явуулахдаа удирдамжийн хүрээнд ажиллах

- Дотоод аудитад хамрагдаж буй байгууллагад хүндрэл учруулахгүй байх

- Дотоод аудитын ажлын явцад хамрагдаж буй байгууллага, газрын талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах

- Дотоод аудитын тайлангийн төслийг тухайн байгууллагын холбогдох албан тушаалтанд танилцуулах, шаардлагатай гэж үзвэл залруулга хийх

- Дотоод аудитын дүрмийг баримтлан, бие даасан байдалтай гүйцэтгэх

- Дотоод аудитын хорооноос гарсан шийдвэр, зөвлөмжийг холбогдох байгууллага, газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

**9. Дотоод аудитын дүнг тайлагнах**

- Дотоод аудитын тайланг байгууллагын удирдлагад танилцуулсан байна.
- Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэх
- Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг холбогдох байгууллагад мэдээлэх.

Аудитын ажилтай холбоотой асуудлаар та бүхэн  
/Sankhuu\_audit\_da@yahoo.com, /99660033/, /99016210/ хаягаар холбогдож болно.

**БЭЛТГЭСЭН:**

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  
ДОТООД АУДИТОР



/Л.ДАГИЙСҮРЭН/  
/А.САНДАГДОРЖ/

# ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:1001

- Удирдлагаас авах ерөнхий асуулга -

|                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                      |
|--------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| №                                    | Байгууллагын нэр:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Дархан Хотын Соёл Амралын Хүрээлэн ОНӨААТҮГ                                                                          |
| 1                                    | Асуулгад хариулсан:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Дарга Л.Тамир                                                                                                        |
| 2                                    | Асуулга авсан:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Дотоод аудитор А.Сандагдорж                                                                                          |
| 3                                    | Огноо:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | 2023.03.22                                                                                                           |
| Байгууллагын үндсэн мэдээлэл         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                      |
| 1                                    | Байгууллагын огноо, шийдвэрийн дугаар, улсын бүртгэлд бүртгэгдсэн регистрийн дугаар:                                                                                                                                                                                                                                                                                                    | 2022.04.18 Дархан сумын ИТХ-ын 15 тогтоол, 4289242                                                                   |
| 2                                    | Байгууллагын нэр хаяг, цахим хуудас                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | "Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн"ОНӨААТҮГ, Дархан-Уул аймаг Дархан сум 14-р баг Миний Монгол Цэцэрлэгт хүрээлэн. |
| 3                                    | Өмчийн хэлбэр:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                                                                 |
| 4                                    | Ажиллагсдын тоо:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | 39                                                                                                                   |
| 5                                    | Жилийн төсөв:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | 600,4 сая                                                                                                            |
| 6                                    | Харъяа байгууллагын тоо:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | байхгүй                                                                                                              |
| 7                                    | Удирдлагын нэр, албан тушаал, томилогдсон огноо:                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Л.Тамир, Газрын дарга, Дархан сумын засаг даргын 2022.04.18 өдрийн Б/33 тоот захирамж                                |
| 8                                    | Удирдлагын ажлаа тайлагнадаг ТЕЗ (эсвэлТҮЗ)-ийн нэр:                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Дархан сумын Засаг Дарга.                                                                                            |
| Байгууллагын талаар ойлголт олж авах |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                      |
| 1                                    | Байгууллагын стратеги зорилго: Инноваци, шинэлэг технологид суурилсан үйлчилгээгээрээ улсдаа тэргүүлнэ.<br>Эрхэм зорилго: Цэвэр, тухтай, эко орчинд хүн төрөлхтний бүтээсэн ололт амжилтуудыг нутагшуулж бүх насныхны хөгжих бүхий л таатай нөхцлийг бүрдүүлнэ.                                                                                                                         |                                                                                                                      |
| 2                                    | Байгууллагын үндсэн үйл ажиллагаа:<br><ul style="list-style-type: none"> <li>- Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн</li> <li>- Дархан 5 цогцолбор</li> <li>- Морин хуур цогцолбор</li> <li>- Дүүжин гүүр</li> <li>- Бурхантай толгой</li> <li>- Найрамдал талбай</li> <li>- Сүрэнгийн гудамжны эд хөрөнгө болон үйл ажиллагааг хариуцан ажиллах.</li> </ul>                                  |                                                                                                                      |
| 3                                    | Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагддаг гол хууль тогтоомж, бодлого, дүрэм, журам:<br><ul style="list-style-type: none"> <li>- Хөдөлмөрийн тухай хууль</li> <li>- Байгууллагын дүрэм</li> <li>- Нийгмийн даатгалын тухай хууль</li> <li>- Татварын тухай хууль</li> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Орон нутгийн өмчийн тухай хууль</li> <li>- Шилэн дансны тухай хууль</li> </ul> |                                                                                                                      |
| 4                                    | Байгууллагын Засаглалын бүтэц. Үүнд:<br>a.Засаглах удирдлага /дээд шатны байгууллага/ Дархан сумын Засаг Дарга<br>b.Гүйцэтгэх удирдлага /Албан тушаал/ Газрын дарга<br>c.Дотоод аудит-Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод аудит хийдэг                                                                                                                                    |                                                                                                                      |

## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:1001

|   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 5 | Байгууллагын эрсдэлээ тодорхойлж, үнэлдэг үү, бууруулах талаар ямар арга хэмжээ авдаг вэ? Байгууллагы эрсдлийг тодорхойлох баримт бичиг, дүрэм журам одоогоор байхгүй. Гэхдээ өдөр тутмын үйл ажиллагаандаа аюултай гэсэн болгоныг засаж залруулан ажилладаг. Хөдөлгөөнт тоглоом ажиллаж байх үед Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг 1 сар тутамд зохион байгуулж ажилладаг.                                            |
| 6 | Байгууллага дотоод хяналтаа хэрхэн хэрэгжүүлдэг вэ? Ажлын тайлан групп чат дээр өдөр тутмын үйл ажиллагааны тайланг өмнө нь дараа гэсэн зурган байдлаар цаг алдалгүй мэдээллэн ажилладаг. Дотоод хяналтын ажилтны орон тоо байдаггүй.                                                                                                                                                                                                      |
| 7 | Байгууллагад тулгамдаж байгаа ямар эрсдэлтэй асуудал байгаа вэ? Чухал шаардлагатай ажлын байранд Мэргэжлийн чадварлаг боловсон хүчин байдаггүй. Жишээлбэл: Цахилгааны инженер, сантехникийн инженер, механик инженер гэх мэт. Цалин бага гэдэг шалтгаантай. Иймд тухайн мэргэжлээр дөнгөж сургууль төгссөн оюутныг сурган ажиллуулах шаардлага гардаг.                                                                                     |
| 8 | Дотоод аудитыг ямар асуудалд илүү анхаарал хандуулахыг хүсч байна вэ? Шинээр байгуулагдсан байгууллагад орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтыг хэрхэн хийх, түүнийг хэрхэн тайлагнах талаар сургалт, зөвлөгөө өгөх. Мөн холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж ажиллах заавар зөвлөгөөг өгч ажиллах. Тайлан, тайлагнах хугацаа, үе шатыг хамгийн түрүүнд ойлгуулах. |

Асуулгад үнэн зөв мэдээлэл өгсөн:

Л.Тамир

Асуулга авсан:

А.Сандагдорж

# ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:1002

Байгууллагын засаглалын талаар нарийвчилсан асуулга ба аудиторын дүгнэлт

1. Байгууллагын нэр: Дархан Хотын Соёл Амралтын Хүрээлэн ОНӨААТҮГ
2. Асуулгад хариулсан: Дарга Л.Тамир
3. Асуулга авсан: Дотоод аудитор А.Сандагдорж
4. Огноо: 2023.03.22

| Засаглах удирдлагын талаар мэдээлэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Засаглах удирдлагын нэр:                                                                                                                                                                         | Дархан сумын засаг дарга                                                                                                                                                                                                                                                                                                 |
| 2                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Засаглах удирдлагын эрх, үүрэг                                                                                                                                                                   | Өдөр тутмын үйл ажиллагааг явуулахын тулд мэргэжил арга зүйгээр хангаж, удирдаж чиглүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах. Ажилчдын хөдөлмөрийг бодитой үнэлж, урамшуулах нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, шинжилгээ хийх. |
| Засаглах удирдлагын оролцооны талаар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 1. Байгууллагын стратеги, зорилго зорилтыг тодорхойлоход оролцдог эсэх. Тийм                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 2. Байгууллагын эрсдэлээ хэрхэн удирдаж /эрсдэлээ тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх зэрэг/ байгаад хяналт тавьдаг эсэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <ul style="list-style-type: none"> <li>▪ Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг улиралд 1 удаа УБ хотын паркийн ажилчидтай хамтран зохион байгуулдаг.</li> <li>▪ Хөдөлмөр хамгаалал, ажлын байрны эрсдлийг бууруулах төлөвлөгөө гарган ажиллаж байгаа.</li> <li>▪ Даатгалын байгууллагатай хамтран хөдөлгөөнт тоглоомын билетийг гэнэтийн ослын даатгалд хамруулахаар зохион байгуулж ажиллаж байна.</li> </ul>                                                                                                                 |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 3. Байгууллагын дотоод ёс зүй, үнэт зүйлсийг үнэлж, дэмждэг эсэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <ul style="list-style-type: none"> <li>▪ Ногоон байгууламж, хөшөө дурсгал манай байгууллагын нэн тэргүүний үнэт зүйл. Үүнийг хайрлан хамгаалах, сэргээн засварлах, арчилгаа тордолтыг хийж ажилладаг.</li> <li>▪ Манай байгууллагын үнэт зүйл ажилчид. Ажилчдыг ажилдаа хайртай, өөриймсөг хандах хандлагын сургалтыг зохион байгуулж ажилладаг. Ажлын байрны эргэцийг барьж ажиллах тал дээр анхааран ажилладаг.</li> <li>▪ Удирдах, удирдуулах арга барилд сургах менежментийн сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байгаа.</li> </ul> |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 5. Гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнтэй байдлыг үнэлж, хариуцлага тооцдог эсэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <ul style="list-style-type: none"> <li>▪ Тооцдог.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| Бусад холбоотой асуудал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 1. Засаглах удирдлага (мөн дотоод аудитын нэгж хэрэв байгаа бол) ба гүйцэтгэх удирдлагын хоорондын түвшинд эрсдэл, хяналтын талаар мэдээлэл солилцдог эсэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <ul style="list-style-type: none"> <li>▪ Дотоод аудитын нэгж байхгүй.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 2. Хөндлөнгийн болон дотоод аудит, бусад гадна орчинд байх харилцагч байгууллагуудтай хангалттай, үр дүнтэй харилцаа байгаа эсэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <ul style="list-style-type: none"> <li>▪ Хангалттай харилцаатай байгаа.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 3. Байгууллагад засаглалтай холбоотой ямар эрсдэлүүд байна вэ?                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| <ul style="list-style-type: none"> <li>▪ Сонгуулийн үр дүн.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| БАЙГУУЛЛАГЫН ЗАСАГЛАЛЫН ТАЛААР АУДИТОРЫН ДҮГНЭХ ХЭСЭГ : (ярилцлагын үр дүн, олж авсан мэдээлэл, баримт материалд үндэслэн аудитор дүгнэх, өгөх зөвлөмжөө тодорхойлох)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| Үнэлгээний түвшин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| Засаглах удирдлагын үүрэг роль                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | 3-р түвшин буюу Томъёолсон (Засаглах удирдлага үйл ажиллагааны журамтай, байнгын үйл ажиллагаатай)                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| Дотоод аудитын нэгжийн үүрэг роль                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 1-р түвшин буюу Эхлэлийн (ДАН-ийн үүргийг бүрэн тодорхойлоогүй, мэргэжлийн ур чадвартай ажилтан дутмаг, зөвхөн шаардлагатай үед дотоод аудит хийдэг. Зөвхөн бэлэн мэдээлэлд дотоод аудит хийдэг) |                                                                                                                                                                                                                                                                                                                          |

# ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:1002

|                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                           |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Стратеги ба эрсдэлийн удирдлага                                                                                                                                                                                                                                         | 2-р түвшин буюу Давтамжтай (Засаглах удирдлагаас стратеги, зорилго зорилтыг үнэт зүйлсийн хамт батлан эрсдэлийг тодорхойлдог.Эрсдэлийн удирдлагын бодлогод зохих оролцоотой.)                                             |
| Ёс зүй ба үнэт зүйлс                                                                                                                                                                                                                                                    | 3-р түвшин буюу Томьёолсон (Ёс зүй, үнэт зүйлсийн талаар харилцаанд байнга ашигладаг.Ажилтнууд үнэт зүйлсээ эрхэмлэн, ёс зүйтэй ажиллаж байгаа эсэхийг үнэлэх системтэй)                                                  |
| Хүний нөөц ба хариуцлагын тогтолцоо                                                                                                                                                                                                                                     | 2-р түвшин буюу Давтамжтай (Ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон боловч мөрддөггүй, ур чадвартай ажилтнууд цөөн, албан тушаалын тодорхойлолт иж бүрэн бус, сургалтын төлөвлөгөөгүй, хүлээх хариуцлага тодорхойгүй) |
| Хяналт, шинжилгээ, үнэлгээ                                                                                                                                                                                                                                              | 3-р түвшин буюу Томьёолсон (Засаглах ба гүйцэтгэх удирдлагын түвшинд хяналт-шинжилгээ үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу хийдэг)                                                                                          |
| Гадаад ба дотоод харилцаа                                                                                                                                                                                                                                               | 3-р түвшин буюу Томьёолсон (Гадаад дотоод харилцааны бүх түвшинд мэдээллийн технологи ашигладаг)                                                                                                                          |
| Гадаад ба дотоод тайлагнал ба ил тод байдал                                                                                                                                                                                                                             | 2-р түвшин буюу Давтамжтай (Гадаад тайлагналын тогтолцоотой. Дотоод тайлагналд мэдээллийн технологи ашигладаг боловч хязгаарлагдмал.)                                                                                     |
| 2. Байгууллагын засаглах удирдлагатай холбоотой одоо мөрдөж байгаа хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байна уу? Засаглах удирдлага нь байгууллагын үндсэн үйл ажиллагаанд салбарын бодлого стратеги, хөтөлбөр арга хэмжээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэхэд оролцдог. |                                                                                                                                                                                                                           |
| 3. Байгууллагын засаглал нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бенчмарк жишиг (COSO, ISO гэх мэт)-тэй нийцэж байна уу? Байхгүй.                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                           |

Асуулгад үнэн зөв мэдээлэл өгсөн:

Дарга, удирдлага ...../Л.Тамир/

гарын үсэг

Асуулга авсан:

Дотоод аудитор...../А.Сандагдорж/

гарын үсэг



## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:1003

Байгууллагын эрсдэлийн удирдлагын талаар нарийвчилсан  
асуулга ба аудиторын дүгнэлт

1. Байгууллагын нэр: Дархан Хотын Соёл Амралын Хүрээлэн ОНӨААТҮГ
2. Асуулгад хариулсан: Дарга Л.Тамир
| 2 | Цалин тооцоолох | R2 | Цагийн бүртгэл иж бүрэн бус байхаас шалтгаалан цалин тооцоололд алдаа гарах | 3              | 3        | 9                 | C2       | Цагийн бүртгэлд үндэслэн цалинг тооцоолох.             | тухай бүр        | Тийм       | бодит хяналтгүй                           | үгүй            |                                   |                                |                  |                                |                  |                                        |
| 3 | Цалин олгох     | R3 | Цалин тооцоололд алдаа гарснаас нэмэгдэл илүү/дууу олгогдох                 | 3              | 3        | 9                 | C3       | Тооцоолсон цалинд байгууллагын удирдлага хяналт тавих. | тухай бүр        | Тийм       | бодит хяналтгүй                           | үйгүй           |                                   |                                |                  |                                |                  |                                        |

# ДОТОО АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:3000

## Илэрсэн асуудлын нэгтгэл

| № | Асуудлын утга                                                                                                                                        | Холбогдох ажлын баримтын дугаар | Асуудлын ангилал (нөлөөтэй эсэх) | Нөлөөлөх хууль тогтоомж, дүрэм, журам                                                                                                                                                                                                                                                | Аудитын тайланд оруулах эсэх |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|----------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|
| 1 | Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон бусад баримт бичигт дотоод хяналтыг хэн хийх, хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй байна. | АБ2003                          | Тийм                             | Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.4.                                                                                                    | Тийм                         |
| 2 | Албан хаагчдад хоол, унааны нэмэгдлийг илүү олгосон                                                                                                  | АБ2003                          | Тийм                             | Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1.3 Төсвийн тухай хуулийн 6.4.1, Тус байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8.1.6                                                                                                                                                                       | Тийм                         |
| 3 | Түрээсийн гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.                                                                                                       | АБ2003                          | Тийм                             | Төсвийн тухай хуулийн 6.3.1, 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1, Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, жишиг үнэ тогтоох тухай тогтоол. | Тийм                         |
| 4 | Хөдөлмөрийн дотоод журмыг ажил олгогч батлаагүй байна.                                                                                               | АБ2003                          | Тийм                             | Хөдөлмөрийн дотоод журмыг "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын 122.1                                                                                                                                                                                                  | Тийм                         |

Хянасан:

СХДААлбаны дарга ..... /Л.Дагийсүрэн/

Бэлтгэсэн:

Дотоод аудитор: ..... /А.Сандагдорж/





**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000**

---

Аудит хийгдсэн байгууллага:  
ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН  
ХҮРЭЭЛЭН ОНӨААТҮГ

\_\_\_\_\_оны\_\_\_\_\_сарын\_\_\_\_\_өдөр

**ДОТООД АУДИТЫН НЭГЖ: ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА**

**- ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -**

Аудитын нэр: Байгууллагын дотоод аудит  
Жил: 2022 он

Огноо 2023 он

**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000**

---

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА:** ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА

**АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:** ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН  
ОНӨААТҮГ

**АУДИТЫН ТӨРӨЛ:**БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АУДИТ

**АУДИТЫН ХУГАЦАА:**

Дотоод аудитын нэгжийн дарга...*Л. Дагийсүрэн* Л.ДАГИЙСҮРЭН

Аудитын багийн гишүүд...*А. Сандагдорж* А.САНДАГДОРЖ

## **ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000**

---

### **АГУУЛГА**

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ
  - 2.1 Аудитын зорилго
  - 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт
  - 2.3 Аудитын аргачлал
- 3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА
  - 3.1 Засаглалын удирдлагын талаар
  - 3.2 Эрсдэлийн удирдлагын талаар
  - 3.3 Дотоод хяналтын талаар
- 4.АУДИТЫН ҮР ДҮН
  - 4.1 Илэрсэн асуудлууд
- 5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ
- 6.НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

**ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000**

---

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА:** ДАРХАН-УУЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА

**АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:** ДАРХАН ХОТЫН СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН  
ОНӨААТҮГ

**АУДИТЫН ТӨРӨЛ:**БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АУДИТ

**АУДИТЫН ХУГАЦАА:**

Дотоод аудитын нэгжийн дарга......Л.ДАГИЙСҮРЭН

Аудитын багийн гишүүд.....А.САНДАГДОРЖ



## **ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000**

---

### **АГУУЛГА**

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ
  - 2.1 Аудитын зорилго
  - 2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт
  - 2.3 Аудитын аргачлал
- 3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА
  - 3.1 Засаглалын удирдлагын талаар
  - 3.2 Эрсдэлийн удирдлагын талаар
  - 3.3 Дотоод хяналтын талаар
- 4.АУДИТЫН ҮР ДҮН
  - 4.1 Илэрсэн асуудлууд
- 5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ
- 6.НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

## **ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000**

### **1. ТАНИЛЦУУЛГА**

Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, 23-06-23/ тоот удирдамжийн дагуу Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэсэн тайланг танилцуулж байна.

### **2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ**

#### **2.1. Аудитын зорилго**

Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж, дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө зөвлөмж өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

#### **2.2 АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ХЯЗГААРЛАЛТ**

Дотоод аудитад Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явц, 2022 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа, цалин хөлс олголт, анхан шатны баримт болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, орлого төвлөрүүлэлт, өмч хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, худалдан авах ажиллагаа, өмнөх хяналт шалгалт, шилэн дансны хөтлөлт зэргийг хамруулсан болно.

Дотоод аудитад Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад дурдагдсан асуудлыг дотоод аудитад хамруулаагүй болно. Үүнд:

Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд "Дундманхаадай аудит" ХХК аудитыг хийж "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна" гэж үзэн Өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн шинжтэй 32 нэр төрлийн цахилгаан тоног төхөөрөмжийг шууд зардлаар бүртгэсэн дансны бичилтийг залруулж, хүн амын орлогын албан татвар 387,3 мянган төгрөг дутуу суутгасанд төлбөрийн акт тогтоож, Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг тус тус өгчээ.

**Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар**

Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд 2022 онд байршуулах нийт 166 мэдээллээс 133 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан бөгөөд энэ нь тус газар нь 2022 оны 4 дүгээр сард байгуулагдаж 5 дугаар сараас мэдээлэл байршуулж эхэлсэн ба 1-4 дүгээр сарын мэдээллийг нөхөн оруулсантай холбоотой байна.

### **2.3. АУДИТЫН АРГА АРГАЧЛАЛ**

Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмаа танилцуулж, засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны талаар асуулга авсан. Мөн аудитын хамрах хүрээнд багтсан асуудлуудын хүрээнд байгууллагаас олж авсан мэдээлэл, бичиг баримтад дүн шинжилгээ хийж, тулган баталгаажуулан, түүврийн аргаар сорил хийлээ. Аудитын эдгээр горимын үр дүнд, дотоод аудитын баг хангалттай аудитын нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно. Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд дараах хууль эрх зүйн баримтуудыг эх үүсвэр болгон ашиглалаа.

- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт
- Улсын салбарын дотоод аудитын гарын авлага
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол "Журам батлах тухай"
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгох журам"

### **3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА**

Дархан сумын ИТХ-ын 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Дархан-Уул аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний газрыг үйл ажиллагааны чиглэлээс нь хамааруулан 2 салгаж Дархан хотын Соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ-г үүсгэн байгуулсан байна.

Тус байгууллага нь Захиргаа удирдлагын хэлтэс, Санхүү үйлчилгээний алба, Тохижилт үйлчилгээний алба гэсэн 3 алба, нийт 39 ажиллагсадтайгаар ажил үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулагдан ажиллаж байна.

## **ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000**

Цэвэр, тухтай, эко орчинд хүн төрөлхтөний бүтээсэн ололт амжилтуудыг нутагшуулж, соёл болоод танин мэдэхүйн боловсролыг үйл ажиллагаандаа шингээж, бүх насны хүмүүсийн хөгжих бүхий л таатай нөхцлийг бүрдүүлэх эрхэм зорилгын дор нийтийн эзэмшлийн байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгүүдийн ногоон байгууламж, гудамж талбайн гэрэлтүүлэг зэргийн тохижилт үйлчилгээг сайжруулах, арчилгаа, хамгаалалт хийх, хөдөлгөөнт тоглоомын төвийн үйл ажиллагааг бүс нутагтаа тэргүүлэх хэмжээнд хүргэхээр үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар нь 2022 онд нийтийн эзэмшлийн байгууламжийн арчилгаа, хамгаалалт, ногоон байгууламжийг сайжруулах чиглэлээр Дархан-50 цогцолбор, Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудад зүлэгжүүлэлт, төрөл бүрийн мод, бут суулгаж, иргэдийн явган замын тохижилтийг тогтмол хийж ажилласан байна. Мөн хөдөлгөөнт тоглоомын үйл ажиллагааг бүрэн хэмжээнд буюу 7 тоглоомыг ажиллуулж иргэдэд үйлчлэн нийт 349.0 сая төгрөгийн борлуулалтын орлого олсон байна.

### **3.1 Засаглалын талаар**

Байгууллагын стратеги төлөвлөгөөг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтуудтай уялдуулан гаргадаг.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Дархан сумын Засаг Даргад тайлагнадаг бөгөөд 2022 оны гүйцэтгэлийн тайлан "Маш сайн" үнэлгээ авсан байна.

### **3.2 Эрсдэлийн удирдлагын талаар**

Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ нь эрсдэл удирдлагын бодлого, журам боловсруулаагүй, ажиллагсад цөөн учраас тусдаа нэгж байгуулах боломжгүй, эрсдэлийн бүртгэл хөтлөөгүй байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн комисс байхгүй. Байгууллагын эрсдэлийн үйл явцыг үнэлэхэд хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн мэдээллийг ашиглах зэрэг үнэлэх шалгууруудын түвшин бүрт байгууллагын эрсдэлийн удирдлагыг тодорхойлж үнэлээгүй байна. Зөвхөн хөдөлгөөнт тоглоом ажиллах үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамруулдаг байна.

## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000

### 3.3 Дотоод хяналтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоо хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" хүрээнд өөрийн байгууллагын онцлогт тохирсон байдлаар дотоод хяналт, шалгалт хийх журам, төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.

### 4.АУДИТЫН ҮР ДҮН

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Илэрсэн асуудал 1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон бусад баримт бичигт дотоод хяналтыг хэн хийх, хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой тусгаагүй байна.                                                                                                                                                                                            |
| Асуудлын ангилал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Нөлөө ихтэй                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| <b>Бодит байдал:</b><br>Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байдлаар "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулан батлуулаагүй. Байгууллагын өдөр тутмын болон санхүүгийн ажил гүйлгээг хянаж баталгаажуулах байдлаар дотоод хяналтын үйл ажиллагаа хязгаарлагддаг.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b><br>- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна, 3.4. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц, харьяалагдах нэгж, объектын тоог харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана. |                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Асуудлын үндсэн шалтгаан:</b><br>Байгууллагын дарга болон албан хаагчид дээрх журмыг мэддэггүй, хууль эрх зүйн мэдлэг дутмаг.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b><br>Байгууллагаас үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль, тогтоомж, дүрэм журам, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэртэй нийцэхгүй байх, үйл ажиллагааны болон төсөв санхүүгийн эрсдэл үүсэх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| Зөвлөмж:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | - Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолоор баталсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу дотоод хяналт шалгалтын журамтай болох, эсхүл хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан заалт оруулах, жил бүр дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах. |



## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                    |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 2</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Албан хаагчдад хоол, унааны нэмэгдлийг илүү олгосон                                                                                |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Нөлөө ихтэй                                                                                                                        |
| <b>Бодит байдал:</b><br>2022 оны 7-р сард 37 албан хаагчид нийт 444,0 мянган төгрөгийн хоол унааны нэмэгдлийг илүү тооцож олгосон.                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                                                    |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b><br>Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1.3. гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах;<br>Төсвийн тухай хуулийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;<br>Тус байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8.1.6.Ажиллагсад хоолны зардлыг 2000 төгрөгөөр, унааны зардлыг 1000 төгрөгөөр ажилласан өдрөөр тооцож сарын эцэст олгоно. |                                                                                                                                    |
| <b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Байгууллагын удирдлагын хяналт сул, нягтлан бодогч ажлын хариуцлага алдсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                    |
| <b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b><br>Цалин хөлсний тооцоолол буруу хийснээс төсөв санхүүгийн алдагдал хүлээх, хууль дүрмийн хэрэгжилт хангалтгүй байх.                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                    |
| <b>Албан шаардлага:</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Хөдөлмөрийн дотоод журмын заалтыг мөрдөх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар Улсын ахлах байцаагчийн Албан шаардлага хүргүүлээ. |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |                                                |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------|
| <b>Илэрсэн асуудал 3</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Түрээсийн гэрээний хэрэгжилт хангалтгүй байна. |
| <b>Асуудлын ангилал</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Нөлөө ихтэй                                    |
| <b>Бодит байдал:</b><br>- Тус газрын дүрмийн 7.9.1-т заасныг үндэслэн Дархан 50 цогцолбор болон Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд иргэдэд худалдаа, үйлчилгээний үзүүлэх зорилгоор иргэд аж ахуй нэгжтэй 5 хүртэлх сараар гэрээ байгуулан ажилласан байна. Гэвч зарим түрээслэгч нар гэрээний хугацааг мөрдөөгүй, хугацаанаас өмнө худалдаа үйлчилгээгээ зогсоосон байна. Үүнд: 6-р сард 3 түрээслэгч 690.0 мянган төгрөг, 7-р сард 9 түрээслэгч 2,358.0 мянган төгрөгийн нийт 3,048.0 түрээсийн төлбөрийг анх гэрээ байгуулсны дагуу төвлөрүүлээгүй, гэрээний хугацаанаас өмнө худалдаа үйлчилгээгээ зогсоосон байна. |                                                |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                |

## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                               |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн тухай хуулийн 6.3.1, 6.4.8,</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28.3,</li> <li>- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1,</li> <li>- Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, жишиг үнэ тогтоох тухай тогтоол.</li> </ul> |                                                                                                                                                                                                                               |
| <b>Асуудлын үндсэн шалтгаан:</b><br>Байгууллагын удирдлага, нягтлан бодогч хууль эрх зүйн мэдлэг дутмаг, Гэрээнд холбогдох хуулийн заалтыг нарийн тусгаж өгөөгүй.                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                               |
| <b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</b><br>Байгууллагын төлөвлөсөн орлого бүрэн гүйцэт төвлөрөхгүй байх, төсөв санхүүгийн алдагдал үүсэх. Бусад өрсөлдөх боломжтой түрээслэгч нарын боломжийг хаах.                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                               |
| Албан шаардлага:                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Түрээсийн төлбөрийн тооцоог нягтлан бодох бүртгэлд тусгах, хугацааны эцэст түрээслэгч нартай тооцоо нийлж, илүү дутуу тооцоог баталгаажуулах. Түрээсийн төлбөрийн дутуу 3,048.0 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлэх. |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                            |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|
| Илэрсэн асуудал 4                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Хөдөлмөрийн дотоод журмыг ажил олгогч батлаагүй байна.                                                     |
| Асуудлын ангилал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Нөлөө дунд                                                                                                 |
| <b>Бодит байдал:</b><br>Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг Дархан сумын Засаг даргаар батлуулсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                            |
| <b>Байх ёстой шаардлага /шалгуур/:</b><br>Хөдөлмөрийн тухай хуулийн 122.1.Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ                                                                                                                                                                                                                               |                                                                                                            |
| <b>Асуудлын үндсэн шалтгаан:</b><br>Байгууллагын удирдлага хууль эрх зүйн мэдлэг дутмаг.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                            |
| <b>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/</b> Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлээгүйгээс ажилтан, ажил олгогч нарын хөдөлмөрийн харилцаа хялбар зохицуулалтгүй, тодорхой бус болох. Мөн ажил олгогч хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдөөгүй нь Зөрчлийн тухай хуулиар зохицуулсан зөрчлийн нэг хэлбэр бөгөөд хөдөлмөрийн дотоод журам батлаагүйгээс хохирол учирсан бол буруутай этгээд учруулсан хохирлоо болон мөнгөн торгууль төлөх эрх зүйн үр дагавартай. |                                                                                                            |
| Зөвлөмж:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | Хөдөлмөрийн дотоод журмыг "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын 122.1-т заасны дагуу батлах. |

## ДОТООД АУДИТЫН АЖЛЫН БАРИМТ:4000

### 5.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад "Дунд" эрсдэлтэй буюу "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгч байна.

| Дүгнэлтийн төрөл        | Дүгнэлтийн тайлбар                                                                                                                                                            |
|-------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сайжруулах шаардлагатай | Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "2-р түвшин"-д байна гэж үзсэн.<br>Аудитаар илэрсэн асуудлын 75% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн |

### 6.НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

6.1. Түрээсийн гэрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28.3-т заасан нөхцлийг бүрэн тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний хугацаа дуусахад тооцоо нийлж баталгаажуулах, түрээсийн төлбөрийг бүрэн төвлөрүүлэхэд анхаарах

6.2. Нягтлан бодох бүртгэлээр тавих дотоодын хяналтыг сайжруулж, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу дансанд бичилт хийх.

6.2. Эрх бүхий байгууллагаас батлан гаргасан санхүү, төсвийн талаарх хууль, дүрэм, журам, эрх зүйн актыг тухай бүр судлан зөв хэрэгжүүлэх.

6.4. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналтын журам, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах.

6.5. Хөдөлмөрийн дотоод журмыг "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын 122.1-т заасны дагуу батлах.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь та бүхний үүрэг хариуцлага юм.

#### ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР



А.САНДАГДОРЖ

#### ТАЙЛАН ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН

АЛБАНЫ ДАРГА



Л.ДАГИЙСҮРЭН

#### ТАНИЛЦСАН:

ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ



Л.ТАМИР

Ц.БАТХИШИГ



